



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ТЕЗ-ИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2022/01/НА-СА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр

Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор С.Батцэцэг

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Дархан-Уул аймаг

2022 он

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	21
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	23
3.8 Аудитын гол асуудал.....	24
3.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..	24
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	24
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	25
4. Аудитын илрүүлэлт.....	25
4.1 Харьяа байгууллагууд.....	25
4.2 Төсвийн ерөнхийлөн захирагч.....	25
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	27

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ДХББЗГ	Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НААҮГ	Нийтийн аж ахуйн үйлчилгээний газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДС	Нийгмийн даатгалын сан
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНӨХК	Орон нутгийн өмчит хувьцаат компани
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УИХ	Улсын их хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
ХБГ	Хүлээгдэж байгаа гүйцэтгэл
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ЭМТ	Эрүүл мэндийн төв



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Б.АЗЖАРГАЛ ТАНАА

**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

45059 Дархан-Уул аймаг,
Дархан сум, 14-р баг
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
E-mail: darkhanuul@audit.gov.mn

2022.04.20 № 268
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийж гүйцэтгэлээ.

Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



009020354

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/				
Код	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		17,307,547.7	31,821,636.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	7,932,717.7	19,398,850.5
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	3,396,873.5	5,539,906.3
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	89,295.0	73,384.0
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	5,818,638.3	6,767,326.5
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	70,023.2	42,168.9
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		268,974,696.7	288,209,221.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	268,974,696.7	288,209,221.4
39200	Биет хөрөнгө		209,104,224.6	228,370,749.7
39300	Биет бус хөрөнгө	13	59,868,872.2	59,836,871.7
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	14	1,600.0	1,600.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		286,282,244.4	320,030,857.5
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		44,885,905.3	46,515,187.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	44,484,461.9	46,100,634.0
41200	Богино хугацаат зээлийн өглөг	16а, 16б	40,396,286.4	41,690,787.6
41300	Өглөг	17а, 17б	4,077,729.0	4,392,255.0
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	10,446.5	17,591.4
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		401,443.4	414,553.1
42200	Урт хугацаат зээл	20а, 20б	401,443.4	414,553.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		241,396,339.1	273,515,670.4
51	Засгийн газрын хувь оролцоо		241,396,339.1	273,515,670.4
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		96,247,057.2	96,323,747.2
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/		22,489,497.5	22,489,497.5
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		46,722,995.7	68,224,187.9
51200	Хуримтлагдсан үр дүн		(35,757,678.0)	(25,115,736.9)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		111,694,466.8	111,593,974.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		286,282,244.4	320,030,857.5

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Код	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	/мянган төгрөгөөр/	
			2020 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		107,702,702.5	115,026,713.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО		25,177,222.8	29,836,858.6
110	Орлогын албан татвар		19,815,546.6	23,740,533.5
1100	Хувь хүний орлогын албан татвар		21,399,079.2	25,013,998.0
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		(1,583,532.6)	(1,273,464.5)
113	Хөрөнгийн албан татвар		2,484,062.4	2,997,398.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж		2,877,613.8	3,098,927.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	64,366,706.1	63,266,173.7
120	Нийтлэг татварын бус орлого		16,130,090.7	14,797,012.2
122	Тусламжийн орлого		65,119.7	3,470.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		48,171,495.7	48,465,691.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		18,158,773.6	21,923,681.1
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	82,653,028.5	83,753,993.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ		82,653,028.5	83,753,993.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		74,447,370.0	76,360,697.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		40,004,896.3	42,711,800.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		5,010,796.7	5,585,849.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		3,877,101.6	3,915,273.5
2104	Хангамж, бараа материалын зардал		1,776,155.3	1,822,263.9
2105	Нормативт зардал		2,816,995.0	2,907,942.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		1,046,993.8	1,500,727.6
2107	Томилолт, зочны зардал		110,491.2	91,599.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		6,606,698.2	2,021,681.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		13,197,241.9	15,803,560.3
212	ТАТААС		2,743,465.2	2,753,634.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		5,462,193.3	4,639,662.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		25,049,674.0	31,272,719.5
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		29,820,567.8	20,797,762.2
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		(4,770,893.8)	10,474,957.3

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/				
Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	238,477,666.8	-	238,477,666.8
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(80,588.3)	-	(80,588.3)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	238,397,078.5	-	238,397,078.5
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	2,015,978.2	-	2,015,978.2
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	115,348.8	-	115,348.8
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	5,646,853.8	-	5,646,853.8
8	Зарласан ногдол ашиг	(8,026.4)	-	(8,026.4)
9	Тайлант үеийн үр дүн	(4,770,893.8)	-	(4,770,893.8)
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	241,396,339.1	-	241,396,339.1
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	241,396,339.1	-	241,396,339.1
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	186,935.4	-	186,935.4
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	241,583,274.6	-	241,583,274.6
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(100,492.0)	-	(100,492.0)
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	180,729.3	-	180,729.3
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	21,397,152.9	-	21,397,152.9
18	Зарласан ногдол ашиг	(19,951.7)	-	(19,951.7)
19	Тайлант үеийн үр дүн	10,474,957.3	-	10,474,957.3
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	273,515,670.4	-	273,515,670.4

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		107,461,733.3	113,105,828.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО		25,177,222.8	29,836,858.6
110	Орлогын албан татвар		19,815,546.6	23,740,533.5
1100	Хувь хүний орлогын албан татвар		21,399,079.2	25,013,998.0
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		(1,583,532.6)	(1,273,464.5)
113	Хөрөнгийн албан татвар		2,484,062.4	2,997,398.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж		2,877,613.8	3,098,927.0
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		1,067,609.9	1,181,174.2
1181	Газрын төлбөр		1,236,615.2	1,385,577.7
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр		573,388.6	532,175.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		63,904,099.6	63,766,061.5
120	Нийтлэг татварын бус орлого		15,732,603.9	15,300,370.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		48,171,495.7	48,465,691.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		18,380,410.9	19,502,908.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		79,336,933.0	76,648,198.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ		79,336,933.0	76,648,198.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		71,150,700.1	69,252,690.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		38,897,157.6	43,540,573.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		5,038,297.9	6,375,797.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		3,564,358.4	4,065,025.1
2104	Хангамж, бараа материалын зардал		9,031,008.7	4,806,532.8
2105	Нормативт зардал		2,796,101.1	2,735,439.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		743,102.5	1,139,703.7
2107	Томилолт, зочны зардал		100,920.0	86,229.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		6,740,378.1	2,944,888.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		4,239,375.8	3,558,501.3
212	ТАТААС		2,743,465.2	2,753,834.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		5,442,767.6	4,641,673.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		28,124,800.3	36,457,630.4
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)		3,288.4	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		25,850,180.8	24,503,944.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		25,850,180.8	24,503,944.3
2200	Дотоод эх үүсвэрээр		25,850,180.8	24,503,944.3
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		(25,846,892.4)	(24,503,944.3)

VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		(1,014,397.7)	(487,553.4)
14	Бусад эх үүсвэр		10,954.3	300,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		730,364.9	492,400.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		294,987.1	295,153.4
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		1,263,510.2	11,466,132.8
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		6,669,207.5	7,932,717.7
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		7,932,717.7	19,398,850.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	86,350,824.4	73,805,448.0	(12,545,376.4)	85.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	65,333,192.3	62,602,456.9	(2,730,735.4)	95.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	57,782,173.4	55,420,027.1	(2,362,146.3)	95.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	37,800,975.7	37,355,767.1	(445,208.6)	98.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,022,558.7	4,937,490.0	(85,068.7)	98.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,347,252.4	3,784,645.4	(562,607.0)	87.1
2104	Хангамж, бараа материалын зардал	1,156,412.2	1,136,289.2	(20,123.0)	98.3
2105	Нормативт зардал	1,247,158.8	1,088,796.2	(158,362.6)	87.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,175,488.9	1,141,154.1	(34,334.8)	97.1
2107	Томилолт, зочны зардал	91,454.7	74,411.0	(17,043.7)	81.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	562,502.9	511,106.8	(51,396.1)	90.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,378,369.1	5,390,367.4	(988,001.7)	84.5
212	ТАТААС	3,442,146.5	3,302,015.2	(140,131.3)	95.9
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	177,459.8	177,459.8	-	100.0
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	3,264,686.7	3,124,555.4	(140,131.3)	95.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,108,872.4	3,880,414.6	(228,457.8)	94.4
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,675,728.6	2,521,428.1	(154,300.5)	94.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,433,143.8	1,358,986.5	(74,157.3)	94.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	20,275,143.8	10,710,591.1	(9,564,552.7)	52.8
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	742,488.3	492,400.0	(250,088.3)	66.3
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	86,350,824.4	76,801,214.2	(9,549,610.2)	88.9
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	47,440,587.0	47,153,739.8	(286,847.2)	99.4
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	31,645,530.4	28,241,359.7	(3,404,170.7)	89.2
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	179,845.8	162,297.9	(17,547.9)	90.2
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	7,084,861.2	1,243,816.7	(5,841,044.5)	17.6

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,409,580.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,393,598.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,729,845.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	378,157.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,963.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,679.6
2104	Хангамж, бараа материалын зардал	123,548.9
2105	Нормативт зардал	563,942.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	401,090.9
2107	Томилолт, зочны зардал	5,006.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	626,531.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	557,925.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	663,752.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	283,814.4
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	379,937.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,982.2
2200	Дотоод эх үүсвэрээр	15,982.2
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,431,056.1
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,431,056.1
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	34,349.4
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	21,475.8

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд ТЕЗ-д бараа материал болон үндсэн хөрөнгийг зөв ангилан бүртгэх, шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 04 дүгээр сарын 01-нээс 2022 оны 04 дүгээр сарын 20-ны хооронд ахлах аудитор С.Батцэцэг гүйцэтгэж, хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 1-10/200 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дархан-Уул аймгийн ТЕЗ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагын санхүүгийн тайлан, Засгийн газрын шугамаар авч, ашиглаж байгаа хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг санхүүгийн нэгтгэсэн тайланд хамааруулна”, 54.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргана” гэж заасны дагуу аймгийн орон нутгийн төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайланг гарган ирүүлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг шинэчлэн батлах тухай,
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”,
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”,
- УИХ-аас “Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль” 2021 оны 6 дугаар сарын 11-нд батлагдаж, 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.

Дархан-Уул аймгийн ТЕЗ нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд нэгтгэсэн төсвийн шууд захирагч бүрийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэгдэн, ашиглагдаж байна.

Аудитын явцад Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээлэлтэй танилцлаа.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь тайлант онд 37 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалт, Сангийн сайдын баталсан нэгдсэн удирдамжийн

хүрээнд 3 байгууллагад, иргэний гомдлын дагуу 1 байгууллагад, аймгийн Засаг даргын баталсан ажлын хэсэгт орж 1, нийт 42 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийжээ.

Хяналт шалгалтаар нийт 917.4 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 30.7 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлэн, 886.7 сая төгрөгийн 60 акт тогтоосноос 86.4 хувь буюу 766.0 сая төгрөгийг барагдуулсан байна.

Хяналт шалгалт хийсэн байгууллага тус бүр дээр илэрсэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, урьдчилан сэргийлэх үүднээс арга зүйн заавар зөвлөмж өгч ажиллажээ.

Мөн ТЕЗ-ийн 110 төсөвт байгууллагын шилэн дансны мэдээллийг шалган, хуулийн хэрэгжилтийг 99.9 хувьтай дүгнэсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг тохируулсан аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн нийт хөрөнгө 320,030.9 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 3,200.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 33,748.6 сая төгрөгөөр буюу 11.8 хувиар нэмэгджээ. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгийн дансуудад материаллаг өөрчлөлт гарсан байна.

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 19,398.9 сая төгрөг болж, өмнөх оноос 11,466.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	0.1	0.8	0.7
Банканд байгаа бэлэн мөнгө	7,932.6	19,398.1	11,465.5
Замд яваа мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Хадгаламж	0.0	0.0	0.0
Дүн	7,932.7	19,398.9	11,466.2
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	1,983.6	5,965.3	3,981.7
Төсөл/ сан	77.7	90.0	12.3
Төрийн сан	5,635.2	12,626.4	6,991.2
ТӨҮГ болон ОНӨҮГ	236.2	717.2	481.0
Дүн	7,932.7	19,398.9	11,466.2

Эх сурвалж: Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Банканд байршиж буй 19,398.1 сая төгрөгийн үлдэгдэлд гадаад валютаарх үлдэгдэл байхгүй байна. Үүнээс 6,055.3 сая төгрөг нь төсөвт байгууллагын, 717.2 сая төгрөг нь орон нутгийн өмчит байгууллагын, 12,626.4 сая төгрөг нь төрийн сангийн үлдэгдэл байна.

Төсөвт байгууллагад бүртгэгдсэн 5,965.3 сая төгрөгийн 2,122.2 сая төгрөг нь орон нутгийн хөрөнгө оруулалтын, 3,252.1 сая төгрөг нь ОНХС-ийн, 514.9 сая төгрөг нь СХС-ийн, 76.1 сая төгрөг нь сумын эрүүл мэндийн төв, ХААИС-ийн лицей сургуулийн үлдэгдэл бол төсөл, сангийн төрөлд бүртгэгдсэн 90.0 сая төгрөг нь байгаль орчныг нөхөн сэргээх барьцаа хөрөнгийн үлдэгдэл байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалт дансны 2,122.2 сая төгрөг нь гүйцэтгэгч байгууллагуудын чанарын баталгааны барьцаа хөрөнгө бол ОНХС-ийн орлогын шилжүүлгийн 3,252.1 сая төгрөг нь 4 төсөл, арга хэмжээ гэрээ байгуулагдаагүй, 2 төсөл арга хэмжээний гүйцэтгэл дутуу шалтгаанаар үлджээ. Энэ нь коронавируст халдварын улмаас бараа материалын үнэ огцом өсөж, хил хааснаас татан авалт удааширсантай холбоотой байна.

Банкин дахь харилцах дансны үлдэгдэл 19,398.1 сая төгрөгийн 96.2 хувь буюу 18,658.5 сая төгрөг нь төрийн сан дахь харилцах дансанд, 3.8 хувь буюу 739.6 сая төгрөг нь арилжааны банканд байршиж байна.

Касст байгаа 0.8 сая төгрөг нь Хонгор сумын "Эмтнаран" ОНӨААТҮГ-ын үлдэгдэл байна.

Төрийн сангийн мөнгөн хөрөнгө

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 5,635.2 сая, эцсийн үлдэгдэл 12,626.4 сая төгрөг болж, 6,991.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа мөнгөн хөрөнгө	5,635.2	12,626.4	6,991.2
Төгрөг	5,635.2	12,626.4	6,991.2
Төрийн сан	5,635.2	12,626.4	6,991.2
Монгол банк			
Арилжааны банк			
Гадаад валют			
Монгол банк			
Замд яваа хөрөнгө			
Нийт дүн	5,635.2	12,626.4	6,991.2

Эх сурвалж: Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд орон нутгийн төсвийн орлогоор 35,248.6 сая төгрөгийг бүрдүүлж, 27,216.2 сая төгрөгийг харьяа байгууллагуудын урсгал санхүүжилтэд, 133.4 сая төгрөгийг өмнөх оны татаас санхүүжилтийн өглөгт, 1,646.5 сая төгрөгийг аймгийн төсвөөс улсын төсөвт татан төвлөрүүлэх шилжүүлэгт зарцуулжээ.

Төрийн сангийн харилцахад байгаа 12,626.4 сая төгрөгийн 5,457.5 сая төгрөг нь аймаг, сумдын ерөнхий орлогын дансны үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт:

ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар анхан шатны баримтын бүрдэл дутуу байх, мөнгөн гүйлгээний тайланг зөрүүтэй илэрхийлэх зэрэг нийт 494.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна. Тухайлбал:

- Анхан шатны баримтын бүрдэл дутуу 52.6 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэлд тусгасан /1 дүгээр сургууль 3.7 сая, 4 дүгээр сургууль 47.7 сая, Гэрэлтэй өрхийн эмнэлэг 1.2 сая/,
- Орхон сумын ОНХС нь өмнөх оны мөнгөн гүйлгээний орлогын дүнг 276.8 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
- “ДХББЗГ” ОНӨААТҮГ мөнгөн гүйлгээний тайлангийн эцсийн үлдэгдлийг 152.5 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлүүдээс 477.2 сая төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 0.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 16.5 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 5,539.9 сая төгрөг болж, өмнөх оноос 2,143.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	228.5	267.7	39.2
Татаас, санхүүжилтийн авлага	0.0	0.0	0.0
Зээлийн хүүгийн авлага	9.9	11.4	1.5
Дансны авлага /ТӨҮГ/	846.1	1,245.0	398.9
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	49.0	23.1	(25.9)
Байгууллагаас авах авлага	384.2	2,475.4	2,091.2
Хувь хүмүүсээс авах авлага	1,879.2	1,517.3	(361.9)
Дүн	3,396.9	5,539.9	2,143.0
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	2,162.6	2,748.6	586.0
Төсөл/ сан	0.0	0.0	0.0
Төрийн сан	33.6	33.6	0.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	1,200.7	2,757.7	1,557.0
Дүн	3,396.9	5,539.9	2,143.0

Эх сурвалж: Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 49.8 хувь буюу 2,757.7 сая төгрөг нь орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт, 0.6 хувь буюу 33.6 сая төгрөг нь төрийн санд, 49.6 хувь буюу 2,748.6 сая төгрөг нь төсөвт байгууллагад байна.

Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд дахь нийт авлагын 1,480.1 сая төгрөг буюу 53.7 хувийг “Дархан Ус суваг” ОНӨХК-ний, 1,224.8 сая төгрөг буюу 44.4 хувийг 5 өрхийн эмнэлгийн авлага эзэлж байна.

Харин төсөвт байгууллагууд дахь нийт авлагын 1,522.3 сая төгрөг буюу 55.4 хувийг сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн авлага, 1,164.6 сая төгрөг буюу 42.4 хувийг сумдын эрүүл мэндийн төвүүдийн авлага эзэлж байна.

Авлагын үлдэгдэл өссөн нь өрхийн эмнэлгүүд болон сумдын эрүүл мэндийн төвүүдэд ЭМД-ын сангаас ковидын эмчилгээний зардлын санхүүжилт дутуу орж ирснээс шалтгаалжээ.

ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 1,135.2 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдэлд зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлэн ажилласнаар 38.0 хувь буюу 431.4 сая төгрөгөөр бууруулан, тайлант оны эцэст 703.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна.

Аудитын илрүүлэлт:

Аудитаар авлага барагдуулахад анхаарч ажиллаагүй байх, шийдвэргүйгээр авлага бууруулсан, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, авлагыг бүртгэлгүй орхигдуулах, илүү бүртгэх зэргээс 117.7 сая төгрөгийн алдаа, зөрчлүүд илэрсэн байна.

Тухайлбал:

- Дархан сумын ЗДТГ авлагыг барагдуулахад анхаарч ажиллаагүй, мөн шийдвэргүйгээр авлага хаасан 33.1 сая, авлагыг бүртгэлд тусгаагүй 16.1 сая төгрөг,
- Дархан сумын СХС 6.2 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж, баталгаажуулаагүй,
- Гэрэлтэй өрхийн эмнэлэг 2.5 сая төгрөгөөр авлагыг илүү бүртгэсэн,
- Ахмадын хөгжлийн төв 6.0 сая төгрөгийн татаас, санхүүжилтийн авлагыг тусгаагүй,
- Орхон сумын СХС 42.3 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй,
- Шарын гол сумын ОНХС тодорхой бус, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 11.4 сая төгрөгийн авлага бүртгэсэн,

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлүүдээс 52.5 сая төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 0.2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоон, 16.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 48.5 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 73.4 сая төгрөг болж, өмнөх оноос 15.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4. Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	89.3	73.4	(15.9)
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	0.0	0.0	0.0
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	0.0	0.0	0.0
Томилолтын урьдчилгаа	0.0	0.0	0.0
Дүн	89.3	73.4	(15.9)
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	0.0	0.0	0.0
Төсөл/ сан	0.0	0.0	0.0
Төрийн сан	0.0	0.0	0.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	89.3	73.4	(15.9)
Дүн	89.3	73.4	(15.9)

Эх сурвалж: Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансанд бүртгэсэн 73.4 сая төгрөгийн үлдэгдэл нь "Дархан Ус суваг" ОНӨХК-ийн бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн урьдчилгаа төлбөр бөгөөд тайлант онд 15.9 сая төгрөгийн ажлын гүйцэтгэлд үндэслэн зардалд хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Тайлант онд урьдчилгаа данстай холбоотой алдаа, зөрчил илрээгүй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 5,818.6 сая төгрөг байснаас оны эцэст 6,767.3 сая төгрөг болж, 948.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	1,317.2	1,779.9	462.7
Бэлэн бүтээгдэхүүн	14.5	0.0	(14.5)
Хангамжийн материал	4,296.3	4,752.2	455.9
Мал амьтад	190.6	235.2	44.6
Дүн	5,818.6	6,767.3	948.7
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	4,826.4	5,764.9	938.5
Төсөл/ сан			
Төрийн сан			
ТӨҮГ болон ОНӨҮГ	992.2	1,002.4	10.2
Дүн	5,818.6	6,767.3	948.7

Эх сурвалж: Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдлийн 14.8 хувийг ОНӨААТҮГ, 85.2 хувийг төсөвт байгууллага эзэлж байна.

Бараа материалын үлдэгдэл өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Төсөвт байгууллагууд хандив, үнэ төлбөргүйгээр 571.8 сая төгрөгийн зөөлөн эдлэл, хичээлийн хэрэглэгдэхүүн, эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, хамгаалах хэрэгсэл, шатахуун, нэг удаагийн хэрэглэгдэхүүнүүдийг хүлээн авсан,

- Малын үүлдэр угсааг сайжруулах зорилгоор ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар Хонгор сумын ЗДТГ-т 25.0 сая, аймгийн ЗДТГ-т 19.6 сая төгрөгийн эцэг мал авч өгсөн,
- НААҮГ-т хөрөнгө оруулалтаар 2021 онд хийх төлөвлөсөн ажлуудын худалдан авах ажиллагаа оны эцэст хийгдсэнээс бараа материал 93.1 сая төгрөгөөр өссөн,
- Ковид халдварт өвчинтэй холбоотойгоор өрхийн эмнэлгүүдэд эм боох материал 139.9 сая төгрөгөөр нэмэгдсэн,
- Ахмадын хөгжлийн төв, 31 дүгээр цэцэрлэг шинээр байгуулагдсанаар 47.7 сая төгрөгийн бараа материал нэмэгдсэн байна.

Аудитын илрүүлэлт:

ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын бүртгэл, тайлагнал, тооллого, анхан шатны баримтын бүрдэлттэй холбоотой 126.1 сая төгрөгийн алдаа, зөрчлүүд илэрсэн байна. Тухайлбал:

- Бараа материалыг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд бичсэн 8.8 сая /Дархан сумын ЗДТГ 6.6 мянга, Шарын гол сумын ИТХ 1.6 сая, 1 дүгээр сургууль 0.6 сая/
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу 45.7 сая /Ахмадын хөгжлийн төв 6.4 сая, Дархан сумын ИТХ 2.2 сая, 23 дугаар цэцэрлэг 3.2 сая, 1 дүгээр сургууль 12.2 сая, 15 дугаар сургууль 15.2 сая, 13 дугаар цэцэрлэг 4.7 сая, Орон нутгийн өмчийн газар 1.8 сая/
- Бараа материалыг ангилал буруу бүртгэсэн 38.7 сая /Гос хот өрхийн эмнэлэг 1.5 сая, 25 дугаар цэцэрлэг 10.3 сая, Ахмадын хөгжлийн төв 3.8 сая, 13 дугаар цэцэрлэг 0.5 сая, 18 дугаар цэцэрлэг 7.9 сая, 8 дугаар цэцэрлэг 7.7 сая, 1 дүгээр сургууль 1.9 сая, Шарын гол сумын соёлын төв 4.1 сая, 14 дүгээр цэцэрлэг 1.0 сая/
- 23 дугаар цэцэрлэг 4.4 сая төгрөгийн бараа материалыг бөөн дүнгээр орлогод авсан,
- Хонгор сумын ЭМТ 13.1 сая төгрөгийн бараа материалыг сайжруулалтаар бүртгэсэн,
- 11 дүгээр сургууль 1.3 сая төгрөгийн багажийг 2 удаа орлогод бүртгэсэн,
- Байгаль орчин аялал жуулчлалын газар үлдэгдлээр байгаа 10.1 сая төгрөгийн бараа материалыг зарлагадсан,
- 10 дугаар цэцэрлэг, 9 дүгээр сургууль 1.9 сая төгрөгийн материалын зарцуулалтыг тайлагнаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлүүдээс 82.2 сая төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 0.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, 6.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 37.2 сая төгрөгийн зөрчлийг даван гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 288,209.2 сая төгрөг болж, өмнөх оноос 19,234.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	122,783.9	127,540.5	4,756.6
Авто тээврийн хэрэгсэл	2,479.7	2,792.0	312.3
Машин тоног төхөөрөмж	7,830.3	8,339.4	509.1
Тавилга эд хогшил	2,455.9	2,611.1	155.2
Зам гүүрийн байгууламж	45,049.1	58,189.5	13,140.4
Батлан хамгаалахын тоног төхөөрөмж	62.3	56.4	(5.9)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	603.8	603.8	0.0
Бусад үндсэн хөрөнгө	16,008.9	16,378.7	369.8
Дуусаагүй барилга байгууламж	10,665.3	10,665.3	0.0
Номын фонд	1,165.0	1,194.1	29.1
Программ хангамж	89.9	70.8	(19.1)
Бусад биет бус хөрөнгө	59,779.0	59,766.0	(13.0)
Биологийн хөрөнгө	1.6	1.6	0.0
Дүн	268,974.7	288,209.2	19,234.5
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	190,845.4	196,003.5	5,158.1
Төсөл/сан	0.0	0.0	0.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	78,129.3	92,205.7	14,076.4
Дүн	268,974.7	288,209.2	19,234.5

Эх сурвалж: Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 38,512.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс 1,045.5 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 20,968.8 сая төгрөгийн хөрөнгийг хандиваар, 7,058.0 сая төгрөгийн хөрөнгийг балансаас баланст болон бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн, 9,014.4 сая төгрөгийн хөрөнгийг бусад эх үүсвэрээр авч, 425.7 сая төгрөгөөр дахин үнэлгээний зөрүү данс нэмэгдсэн байна.

Тайлант онд 3,088.0 сая төгрөгийн хөрөнгө данснаас хасагдсанаас эрх бүхий байгууллагын шийдвэрээр 1,474.6 сая төгрөгийн хөрөнгийг акталж, 399.3 сая төгрөгийн хөрөнгийг балансаас баланст шилжүүлэн, 1,214.1 сая төгрөгийн хөрөнгийг бусад шалтгаанаар хасаж, тайлант хугацаанд 16,189.9 сая төгрөгийн элэгдэл байгуулжээ.

Үндсэн хөрөнгийн өсөлтийн гол шалтгаан нь 2021 онд улс, орон нутгийн төсөв болон ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 17,680.2 сая төгрөгийн авто зам, түүний сайжруулалт, авто зогсоол, замын тэмдэг, тэмдэглэгээг орлогод авсан, шинээр байгуулагдсан 31 дүгээр цэцэрлэг 1,153.8 сая, Ахмадын хөгжлийн төв 1,686.0 сая төгрөгийн хөрөнгө бүртгэсэн байна.

Дуусаагүй барилгын дансанд 10,665.3 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаагаас Биеийн тамир спортын газарт 10,585.8 сая, Шарын гол сумын ЗДТГ-т 79.5 сая төгрөгийн хөрөнгө байна.

Монгол Улсын Засгийн газар, БСШУЯ-ны захиалгаар улсын төсвийн санхүүжилтээр Дархан-Уул аймагт баригдаж буй "Спорт цогцолбор"-ын барилга 2011 онд эхэлсэн бөгөөд технологийн өөрчлөлт, барилгын материалын үнийн өсөлт зэргийн нөлөөнөөс анхны төсөвт өртөг нь өссөнөөс царцаагдаж, одоогоор ажлын гүйцэтгэл 80 хувьтай явагдаж байна. Энэхүү хөрөнгийн ажлын гүйцэтгэл 10,585.8 сая төгрөг нь Биеийн тамир спортын газарт бүртгэлтэй байна.

Шарын гол сумын ЗДТГ-ын дуусаагүй барилгын дансанд бүртгэлтэй 79.5 сая төгрөгийн барилгын ажил дуусаж, ашиглагдаж байгаа ч барилга байгууламжийн дансанд шилжүүлэн бүртгээгүй тул төсвийн шууд захирагчийн аудитаар албан шаардлага хүргүүлжээ.

Аудитын илрүүлэлт:

ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, дахин үнэлгээний нэмэгдэл аль хөрөнгөд хамаарах нь тодорхойгүй, хасах үлдэгдэлтэй илэрхийлэх, дахин үнэлгээг илүү бүртгэх, дансны

бичилтийг буруу хийх, элэгдлийг зөв тооцоогүй, ангилал зөрүүлэн бүртгэх, өмнөх оны зөвлөмжийг биелүүлээгүй байх зэрэг үндсэн хөрөнгийн данстай холбоотой 3,951.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрлээ. Тухайлбал:

- Хөрөнгийг бүртгэлд тусгаагүй 2,967.6 сая /НААҮГ 2,943.0 сая, аймгийн ЗДТГ 21.3 сая, 5 дугаар цэцэрлэг 3.3 сая/,
- Хүүхдийн номын ордны үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний 17.8 сая төгрөгийн нэмэгдэл нь аль хөрөнгөд хамаарах нь тодорхойгүй,
- Шарын гол сумын ЗДТГ өмнөх оны аудитаар өгсөн 79.5 сая төгрөгийн дуусаагүй барилгыг хөрөнгөд бүртгэх талаар холбогдох байгууллагад хүсэлт гаргаж шийдвэрлүүлээгүй,
- ГБХЗХГ-ын үндсэн хөрөнгийн үлдэгдэл тооллогын бүртгэлээс 207.1 сая төгрөгөөр зөрүүтэй,
- Хонгор сумын ЭМТ 10.4 сая төгрөгийн эм худалдан авах гэрээгээр тоног төхөөрөмж худалдан авсан,
- 16 дугаар цэцэрлэг 3.2 сая төгрөгийн тавилга, эд хогшлыг тоног төхөөрөмжид бүртгэсэн,
- НААҮГ 1.0 сая, 13 дугаар цэцэрлэг 0.1 сая төгрөгийн хөрөнгийг хасах утгатай илэрхийлсэн,
- “Тулга сувилал” ОНӨААТҮГ 4.9 сая төгрөгийн 17 нэр төрлийн хөрөнгийн ашиглах жилийг хасах утгатай оруулсан,
- 6 дугаар сургууль үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг 67.0 сая төгрөгөөр илүү илэрхийлсэн,
- Гос хот өрхийн эмнэлэг 3.1 сая дансны бичилтийг буруу хийсэн,
- Элэгдлийн зардлыг зөв тооцоогүй 561.5 сая /30 дугаар цэцэрлэг 2.4 сая, НААҮГ 442.1 сая, 1 дүгээр сургууль 80.0 сая, 14, 17 дугаар цэцэрлэгүүд 9.0 сая, БТСГ 28.0 сая/,
- Ахмадын хөгжлийн төв 1.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалаар, 4.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг ангилал зөрүүлж, 11.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг зардлаар бүртгэсэн,
- 13 дугаар цэцэрлэг үндсэн хөрөнгөд 5.3 сая төгрөгийн бараа материал бүртгэсэн.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлүүдээс 3,634.5 сая төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 316.6 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 40,650.9 сая төгрөг байснаас оны эцэст 44,885.9 сая төгрөг болж, 4,235.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Богино хугацаат өр төлбөрийн дүн	44,484.4	46,551.4	2,067.0
Богино хугацаат зээлийн өглөг	40,396.3	41,690.8	1,294.5
Ажилчидтай холбогдсон өглөг	13.9	170.9	157.0
Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.0	0.6	0.6
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	1,178.1	2,122.2	944.1
Бусад өглөг	2,885.7	2,549.3	(336.4)
Урьдчилж орсон орлого	10.4	17.6	7.2
Урт хугацаат өр төлбөрийн дүн	401.5	414.5	13.0
Урт хугацаат зээлийн өглөг	401.5	414.5	13.0
Нийт дүн	44,885.9	46,965.9	2,080.0
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төрийн сан	40,396.3	41,566.0	1,169.7
Төсөвт байгууллага	2,002.3	3,406.7	1,404.4
ТӨҮГ болон ОНӨҮГ	2,487.3	1,993.2	(494.1)
Дүн	44,885.9	46,965.9	2,080.0

Эх сурвалж: Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн өсөлтөд Азийн хөгжлийн банкны эх үүсвэрээр хэрэгжиж байгаа “Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН-3244/3245 төсөл”-ийн зээлийн 1,294.5 сая, хөрөнгө оруулалтын ажлын чанарын баталгааны барьцааны 944.1 сая төгрөгийн өсөлтүүд голлон нөлөөлжээ.

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 2,144.6 сая төгрөгийн барьцаа, 41,690.8 сая төгрөгийн гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн зээл, 2,716.0 сая төгрөгийн бусад өр байна.

Барьцаа дансанд хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэлийн чанарын баталгааны барьцаа 2,122.2 сая, сумдын байгаль орчныг нөхөн сэргээх барьцаа 22.4 сая төгрөгийн өр төлбөр байна.

Бусад өр төлбөрийн 2,716.0 сая төгрөгийн үлдэгдэлд дансны болон татвар, нийгмийн даатгалын шимтгэл, ноогдол ашиг, урьдчилж орсон орлогын 1,993.2 сая төгрөгийн ОНӨААН-ийн, байгууллага, хувь хүмүүст төлөх болон ажилчидтай холбогдсон 722.8 сая төгрөгийн төсөвт байгууллагын өр байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд “Дархан Ус суваг” ОНӨХК-ийн хөрөнгө оруулалт, их засварын эх үүсвэр дутагдсан шалтгаанаар авсан урт хугацаат зээлийн өглөг 414.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нийт өр төлбөрөөс хугацаа хэтэрсэн болон тооцоо нийлж баталгаажуулаагүй өглөг байхгүй.

Аудитын илрүүлэлт:

ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар өр төлбөрийг бүртгээгүй, орлогоор бүртгэсэн, өмнөх онд өр төлбөр үүсгэлгүйгээр тайлант оны төсвөөс зарцуулсан, төсвийг зохистой удирдаагүйгээс өр төлбөр үүсгэсэн, өр төлбөрийн дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй, төсвийг зохистой удирдаагүйгээс өр төлбөр үүсгэх, өр төлбөрийг бүртгэлгүй орхигдуулах зэргээс 29.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрлээ. Тухайлбал:

- НААҮГ 5.0 сая, 6 дугаар цэцэрлэг 0.6 мянга, Захирагчийн алба 0.4 сая төгрөгийн өглөгийг тайланд тусгаагүй,
- Аймгийн ЗДТГ 2.9 сая, Музей 1.1 сая, 4 дүгээр цэцэрлэг 0.2 сая төгрөгийг өмнөх онд өр төлбөр үүсгэлгүйгээр тайлант оны төсвөөс зарцуулсан,
- Шарын гол сумын ЗДТГ 0.4 сая өглөгийг бүртгээгүй,
- Төсвийг зохистой удирдаагүй, тооцооллыг буруу хийснээс 14 дүгээр цэцэрлэг 0.2 сая, 17 дугаар цэцэрлэг 0.1 сая, Ахмадын хөгжлийн төв 0.8 сая, ДХББЗГ 16.6 сая төгрөгийн өглөг үүсгэсэн,
- Хонгор сумын ЗДТГ 0.4 сая төгрөгийн өглөгийг бүртгээгүй,
- Гэрэлтэй өрхийн эмнэлэг 0.3 сая төгрөгийн өр төлбөрийг орлогоор бүртгэсэн.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлүүдээс 6.7 сая төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 1.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэн, 21.5 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 241,396.3 сая төгрөг байснаас тайлант онд 2,918.6 сая төгрөгөөр нэмэгдэж, оны эцэст 241,396.3 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

Хүснэгт №8. Засгийн газрын хувь оролцооны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	96,247.0	96,323.7	76.7
Өмч /ТӨҮГ/	22,489.5	22,489.5	0.0
Эздийн өмчийн бусад хэсэг	46,723.0	68,224.2	21,501.2
Хуримтлагдсан үр дүн	(35,757.7)	(25,115.7)	10,642.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	111,694.5	111,594.0	(100.5)
Нийт дүн	241,396.3	273,515.7	32,119.4
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төрийн сан	(35,084.6)	(29,356.7)	5,727.9
Төсөл/сан	0.0	0.0	0.0
Төсөвт байгууллага	198,320.7	208,399.0	10,078.3
ТӨҮГ болон ОНӨҮГ	78,160.2	94,473.4	16,313.2
Нийт дүн	241,396.3	273,515.7	32,119.4

Эх сурвалж: Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

“Засгийн газрын оруулсан капитал” данс нь Ахмадын хөгжлийн төв болон 31 дүгээр цэцэрлэг шинээр ашиглалтад орсноор 76.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

“Эздийн өмчийн бусад хэсэг” данс хөрөнгө оруулалт, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудаар нэмэгдсэн байна. Тухайлбал “Дархан орон нутгийн зам тээвэр” ОНӨААТҮГ-т шинээр ашиглалтад хүлээн авсан 17,684.4 сая төгрөгийн автозам, авто зогсоол, замын тэмдэг, “Мэдээлэл технологийн алба” ОНӨААТҮГ-т 10.4 сая төгрөгийн хэвлэл мэдээллийн тоног төхөөрөмж, Ахмадын хороонд 104.0 сая төгрөгийн барилгын өргөтгөл, “Эмтнаран” ОНӨААТҮГ-т 365.9 сая төгрөгийн автомашин, тоног төхөөрөмж, “Дархан Ус суваг” ОНӨХК-д 2,837.0 сая төгрөгийн барилга, тоног төхөөрөмж, мөн “Орхон тохижилт” ОНӨААТҮГ-т 499.5 сая төгрөгийн өргөх станц, гүний худаг, цэвэр усны шугам, хашаа, хөшөө зэрэг хөрөнгийг үнэ төлбөргүйгээр бүртгэсэн нь нөлөөлжээ.

Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансны бууралт нь төсөвт байгууллагуудын дахин үнэлгээний нэмэгдэлтэй хөрөнгийг акталж устгаснаас шалтгаалсан байна.

Тайлант үеийн үр дүнгийн өсөлтийн шалтгаан нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Тайлант онд цэвэр хөрөнгө, өмчтэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Аймгийн ИТХ-ын 2020 оны 2/02 дугаар тогтоолоор аймгийн төсвийн суурь орлогыг УИХ-аас хянаж ирүүлсэн суурь орлогоос 2,119.5 сая, өмнөх оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 7,364.9 сая, төсвийн төслөөс 33.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 27,521.9 сая төгрөгөөр баталжээ.

Төсвийн жилийн дундуур Монгол Улсын Их Хурлын 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар тодотгол хийхдээ Дархан-Уул аймгийн 2021 оны орон нутгийн төсвийн суурь орлогод өөрчлөлт оруулаагүй байна.

Харин зарлагын төсвийн саналыг урьдчилан тооцсон суурь зарлагаас 11,718.8 сая, 2020 оны ХБГ-ээс 7,917.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, 28,985.1 сая төгрөгөөр төсөвлөснийг Сангийн яам 17,472.8 сая төгрөгөөр хянажээ.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 2/02 тогтоолоор 2021 оны орон нутгийн төсвийн зарлагыг орлогын эх үүсвэрт тулгуурлан Сангийн яамны хянасан дүнгээс 4,855.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 22,328.0 сая төгрөгөөр баталсан нь өнгөрсөн оны зарлагаас 976.8 сая төгрөгөөр өссөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Аймгийн хэмжээнд орон нутгийн төсвийн орлого 35,248.6 сая төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 3,785.1 сая төгрөгөөр буюу 12.0 хувиар давж биелснээс татварын орлого 2,845.3 сая, татварын бус орлого 939.8 сая төгрөгөөр тус тус давсан байна.

Хүснэгт №9. Орлогын гүйцэтгэл /сая төгрөг/

Орлогын нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	27,773.9	30,619.2	2,845.3	110.2
Татварын бус орлого	3,689.6	4,629.4	939.8	125.5
ОНХС-ийн орлогын шилжүүлэг	8,675.8	8,675.8	0.0	100.0
Тусгай зориулалтын шилжүүлэг	39,789.5	39,789.5	0.0	100.0
НДС-аас санхүүжих	179.8	162.3	(17.5)	90.3
ТЗШ-ийн байгууллагуудын өөрийн орлого	107.2	124.9	17.7	116.5
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	6,135.0	0.0	(6,135.0)	0.0
ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО	86,350.8	84,001.1	(2,349.7)	97.3

Орлогын нэр төрлөөр үзвэл орлогын албан татварын орлого 1,480.8 сая, өмчийн татварын орлого 540.3 сая, төлбөр хураамжийн орлого 755.4 сая, хүү торгуулийн орлого 449.3 сая, сум хөгжүүлэх сангийн орлого 210.3 сая төгрөгөөр давжээ.

Орлого давсан шалтгаан нь:

- **Орлогын албан татварын орлого:** Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого гүйцэтгэлээр 628.4 сая, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн өсөлттэй холбоотойгоор хөрөнгө борлуулсны орлогын албан татвар 415.8 сая, хадгаламжийн хүүгийн орлого гүйцэтгэлээр 352.4 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн,
- **Өмчийн татварын орлого:** Өмнөх оны үлдэгдлээс 173 иргэн, аж ахуйн нэгжийн 470.5 сая төгрөгийн авлагыг барагдуулсан,
- **Хүү, торгуулийн орлого:** 2021 онд УИХ-аар “Өршөөл үзүүлэх тухай” хууль батлагдаж автомашины торгох шийтгэлийн төлбөрийг 50 хувийг чөлөөлөх шийдвэр гарснаар цагдаагийн газрын хүү торгуулийн орлого 388.7 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Аймгийн орон нутгийн тусламж, санхүүжилтийн орлогыг 54,887.3 сая төгрөгөөр төлөвлөснөөс 48,752.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа нь урьд оны үлдэгдэл 6,135.0 сая төгрөгийг зарцуулаагүйтэй холбоотой байна.

ОНХС, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого 48,465.3 сая төгрөгөөр буюу 100.0 хувь, урьд оны үлдэгдэл 6,135.0 сая төгрөгийг тайлант онд зарцуулаагүй, тайлант жилийн гүйцэтгэлд тулгуурлан НДС-ийн санхүүжилт 162.3 сая төгрөг буюу 90.2 хувь, ТЗШ-ийн байгууллагын өөрийн орлого 124.9 сая төгрөг буюу 116.5 хувиар тус тус төвлөрчээ.

Төсвийн зарлагын гүйцэтгэл

Аймгийн орон нутгийн 2021 оны төсвийн нийт зарлага ба цэвэр зээлд 86,350.8 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 73,805.4 сая төгрөг зарцуулж, зардлын гүйцэтгэл 85.5 хувьтай гарчээ.

Хүснэгт №10. Зардлын гүйцэтгэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урсгал зардал	65,333.2	62,602.4	(2,730.8)
Хөрөнгийн зардал	20,275.1	10,710.6	(9,564.5)
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	742.5	492.4	(250.1)
Нийт зарлагын дүн	86,350.8	73,805.4	(12,545.4)

Орон нутгийн төсвийн урсгал зардал 62,602.4 сая төгрөг буюу 95.8 хувь, хөрөнгийн зардал 10,710.6 сая төгрөг буюу 52.8 хувь, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 492.4 сая төгрөг буюу 66.3 гүйцэтгэлтэй гарчээ.

Урсгал зардлын гүйцэтгэлд улсын төсөвт төвлөрүүлэх шилжүүлэг 2.6 хувийг эзэлж байгаа бол тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын зардал 68.6 хувийг эзэлж, 98.3 хувийн, орон нутгийн төсөвт байгууллагын зардал 28.8 хувийг эзэлж, 90.1 хувийн тус тус гүйцэтгэлтэй гарсан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор хэмнэлтийн горимд шилжүүлж, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардлыг тэвчих, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргах, шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, ажлын байр нэмэгдүүлэхгүй байхаар үүрэг болгосон, Ковид-19 халдварын улмаас зарим байгууллагын үйл ажиллагааг хязгаарласнаас шалтгаалан урсгал зардлыг 2,730.7 сая төгрөгийн хэмнэжээ.

Хөрөнгийн зардлын гүйцэтгэл 52.8 хувь буюу 10,710.6 сая төгрөг байгаа нь ковид-19 халдварын улмаас хөл хорио тогтоосон, урд хил хаалттай байснаас хамаарч бараа материалын үнэ огцом өсөж, татан авалт удааширсантай холбоотой байна.

2021 онд сумдад 3,859.3 сая төгрөгийг татаасаар олгож, оны эцэст ТЗШ-ийн байгууллагуудын зарцуулаагүй үлдэгдэл 1,646.5 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсвийн шууд захирагчийн нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд нийт 3,431.1 сая төгрөг төвлөрснөөс гүйцэтгэлээр 3,393.6 сая төгрөгийг урсгал зардалд, 16.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулж, 21.5 сая төгрөгийг буцаан төвлөрүүлжээ.

Нэмэлт санхүүжилтийг Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих” журмын хүрээнд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн ерөнхийлөн захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аймгийн Засаг даргын 2021 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 64 зорилтот түвшинд 286 арга хэмжээ баталснаас гүйцэтгэлээр 95.87 хувийн биелэлттэй байна.

Хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 4 арга хэмжээ зорилтот түвшиндээ хүрээгүй нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалтын дагуу түр хойшлуулсан, төсөв хүрэлцээгүй зэргээс шалтгаалсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

3.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны цахим хуудсанд нийт 90 мэдээлэл байршуулахаас 87 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд мэдээ, мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж байх зөвлөмж өгөв.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох зарим заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Харьяа байгууллагуудад илэрсэн нийцлийн аудитын асуудлаар нийт 5,359.6 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 6.0 сая төгрөгийн 1 зөрчлийг залруулж, 2,263.1 сая төгрөгийн 9 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 28.2 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргасан тул хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлж, 3,062.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 24 зөвлөмжийг өгсөн байна.

Мөн аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн сан болон хөрөнгө оруулалтын санхүүгийн тайлангийн аудитаар тендерийн үнэлгээний хороонд хуульд заасан бүрэлдэхүүнийг томилоогүй, төсөл арга хэмжээний нэр байршлыг өөрчилж тодотгосон, хөрөнгө оруулалтын зардлаас урсгал зардлыг санхүүжүүлсэн, 1 ажлыг 2 төсөл арга хэмжээнд хуваасан зэрэг зөрчлүүд илэрч, 45.0 сая төгрөгийн 6 зөвлөмжийг хүргүүлжээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

Хүснэгт.11 Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар тогтоосон акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	-	-	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-	-	-
Зөвлөмж	3	1,135.2	3	1,135.2	-	-	-
Нийт дүн	3	1,135.2	3	1,135.2	-	-	-

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид төлбөрийн акт, албан шаардлага өгөөгүй ба 3 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц чухал асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 439.0 сая төгрөгийн 5 алдаа, зөрчил илэрснээс 10.8 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 428.3 төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй нийт алдаа, зөрчил 428.3 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 3,200.3 сая төгрөгөөс бага тул "Зөрчилгүй" дүгнэлт өгсөн.

4.1 Харьяа байгууллагууд

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 119 байгууллага, 5 төрийн сангийн, 16 орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн, нийт 140 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс бүх байгууллага аудитад хамрагдсан бөгөөд үүнээс 112 байгууллага дүгнэлт гаргуулж, хувийн 9 сургууль, 10 цэцэрлэгийн орон нутгийн төсвөөс авсан татаас болон аймаг, сумдын ерөнхий орлого, аймгийн Засаг дарга, Байгаль орчныг нөхөн сэргээх барьцаа хөрөнгийн дансдууд түүвэрт хамрагджээ.

Аудитад хамрагдсан харьяа бүх байгууллагын санхүүгийн тайланд "Зөрчилгүй" дүгнэлт өгсөн байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 21,011.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 13,451.9 сая төгрөгийн 117 алдааг аудитын явцад залруулж, 23.0 сая төгрөгийн 47 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2,553.4 сая төгрөгийн 27 зөрчлийг арилгах, 28.2 сая төгрөгийн 1 хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлж, 4,954.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 127 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

4.2 Төсвийн ерөнхийлөн захирагч

4.2.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулсан алдаа

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд дараах алдаанууд илэрлээ. Үүнд:

- Залуучууд театрын мөнгөн гүйлгээний тайланд 8.7 сая төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлогыг туслах үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн,
- Аймгийн ИТХ-ын үр дүнгийн тайланд 2.1 сая төгрөгийн хандив тусламжийн орлогыг ангилал зөрүүлэн бүртгэсэн байна.

4.2.2 Акт, албан шаардлага

Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага байхгүй болно.

4.2.3.Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн данс

1.1 Илрүүлэлт: Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны цахим хуудсанд нийт 90 мэдээлэл байршуулахаас 87 мэдээллийг хуульд заасан хугацаанд мэдээлсэн бөгөөд төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарыг 7 дугаар сард, төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг 1 ба 3 дугаар улиралд хоцроож мэдээлсэн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээ, мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж байх.

2. Бараа материал

2.1 Илрүүлэлт: Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяаны 4 байгууллага 359.2 сая төгрөгийн бараа материалыг НББ-ийн бодлогын баримт бичигт тусгаагүй ангиллаар бүртгэсэн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд залруулга хийх.

3. Үндсэн хөрөнгө

3.1 Илрүүлэлт: Аймгийн ЗДТГ 69.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг НББ-ийн бодлогын баримт бичигт тусгаагүй ангиллаар бүртгэсэн байна.

3.2 Өгсөн зөвлөмж: 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд залруулга хийх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

5.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

№	Байгуу- лагын нэр	Ауди- тын код	Аудитын санал дүгнэлт					Үүнээс					Нийт алдаа, зөрчлийн дүн			Үүнээс					Зөвлөмж	
			Бүгд	Зөрчллийн				Залуулга	Акт	Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж								
				Хязгарлалтай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагтлах	Түүвэрт хамруулсан			тоо	Дүн	тоо	Дүн		тоо	Дүн	тоо	Дүн				
1	ТЭЗ		1	1			5	439,041.0	2	10,779.6	-	-	-	-	-	-	-	-	-	-	3	428,261.4
2	ТТЗ		4	4			16	6,672,376.2	7	5,331,031.6	-	-	2	-	-	-	-	-	-	-	7	1,341,344.6
3	ТШЗ		119	91		28	13,785,267.6	95	7,726,661.5	40	21,638.8	22	2,478,881.1	1	28,238.7	99	3,529,847.5					
4	ОНӨААН		16	16			46	553,634.9	15	394,205.9	7	1,323.4	3	74,527.5	-	-	21	83,578.1				
	Дүн		140	112		28	21,450,319.7	119	13,462,678.6	47	22,962.2	27	2,553,408.6	1	28,238.7	130	5,383,031.6					

/мянган төгрөгөөр/

